



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/10

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймаг болон БНХАУ-ын Алтай, Цонж аймгийн найрамдалт хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарыг туршлага судлуулах, хамтарч ажиллах уулзалт арга хэмжээнд 31,060,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 31,060,000 (гучин нэгэн сая жаран мянга) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.11-т тусгагдсан Төрийн албан хаагчийг чадавхжуулах хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 08-ны өдрийн
А/10 дугаар захирамжийн хавсралт



ХОВД АЙМАГ БОЛОН БНХАУ-ЫН АЛТАЙ, ЦОНЖ АЙМГИЙН
НАЙРАМДАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ТӨРИЙН
АЛБАН ХААГЧДЫГ ТУРШЛАГА СУДЛУУЛАХ, ХАМТАРЧ
АЖИЛЛАХ УУЛЗАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Чиглэл	Явах зам (км)	Явах хүний тоо	Хугацаа	Гарах зардал
1	2	3	4	5	7
1	Ховд-Булган сум-Ховд чиглэлд явах автобусны хөлс	850	34*1	2024.11	2,500,000
2	Аяллын компаний зардал (унтлагын)	1780	34*770,000	2024.11	26,180,000
4	Хоолны зардал		34*70000	2024.11	2,380,000
	Нийт				31,060,000

-oOo-